



ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ

АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-ын зар	03
ХЭЭБХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн тогтоол	04
ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:	06
Шийдвэрлэх асуудал:	
1. 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах.	
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл	10
Тооллогын комиссын бүрэлдэхүүн	11
Саналын хуудасны загвар	13

ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАРЛАЛ

ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-38 дугаар тогтоолын дагуу Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгийг үндэслэн, хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит бус хурлыг үүгээр зарлаж байна.

ХасБанкны хаяг байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх өдөр: 2026 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Брокер, дилерийн компаниудад хүргүүлж, ХасБанкны цахим хуудас, ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнд байрлуулна.

Эцнээ санал цахимаар хүлээн авах хугацаа: 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд хүлээн авна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухай.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалуудтай танилцах бол 2026 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ХасБанкны цахим хуудас (www.xacbank.mn)-т, хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшн-д эсвэл ажлын өдрүүдэд өөрт ойр үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хандах боломжтой.

Холбоо барих:

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@xacbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2026 оны 08 дугаар сарын 25-ны өдөр
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХЭЛБЭРЭЭР, ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20.26 оны 08 сарын 20 өдөр

№ R-2026-38

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") 2026 оны 08 дугаар сарын 19-20-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ НЬ:

1. ТУЗ нь 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-37 дугаар тогтоолоор Банкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар шийдвэрлэснийг; мөн
2. Дээрх асуудлыг эцэслэн батлах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт хэлбэрээр, цахимаар зохион байгуулах нь зүйтэй гэж ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ НЬ:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж хуралдуулсугай.
2. Банкны дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ХЭЭБХ-ын даргаар Банкны ТУЗ-ийн дарга Санжай Гүптаг зарласугай.
3. ХЭЭБХ-ыг Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Б.Биндэръяаг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
4. ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн ажлын албанд даалгасугай.
5. ХЭЭБХ-ыг хуралдуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны цахим хуудас (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
6. ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр байхаар тогтоосугай.

7. ХЭЭБХ-аар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, хурлын танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбогдох баримт бичгийг 2026 оны 08 дугаар сарын 28-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
8. ХЭЭБХ-ын хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭБХ-ын хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, ХЭЭБХ-ын Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, ХЭЭБХ-ын саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшнээр дамжуулан танилцах боломжийг хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
10. ХЭЭБХ-аас гаргасан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, мөн холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-нд хүргүүлэхийг ТУЗ-ийн ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

Шийдвэрлэх асуудал

2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай танилцуулга

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг болон ХасБанк ХК-ийн Дүрмийн 8.6(ii) дахь заалт, мөн ТУЗ-ийн 2026 оны 08 дугаар сарын 19-20-ны өдрийн хурлын шийдвэрт үндэслэн ХасБанк ХК-ийн 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар ногдол ашиг тараахыг санал болгож байна:


Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг:	18.00 төгрөг
Ногдол ашгийн нийт дүн:	18.9 тэрбум төгрөг (халаасны хувьцааны тооноос хамааран өөрчлөгдөж болзошгүй)
Ногдол ашиг тараах огноо:	Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл ХЭЭБХ-ын ногдол ашиг хуваарилах шийдвэр батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор
Ногдол ашиг тараах хэлбэр:	ҮЦТХТ-өөр дамжуулан дансаар олгоно
Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр:	ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болох 2026 оны 09-р сарын 14-ний өдөр

Өмнөх ногдол ашгийн мэдээлэл

ХасБанк ХК 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18.00 төгрөгийн ногдол ашиг тараахаар санал болгож байна.


Өмнөх оны ногдол ашгаас олгосон ногдол ашиг

Тэрбум төгрөг



Цэвэр ашиг

Тэрбум төгрөг



Ногдол ашиг тараасны дараах өөрийн хөрөнгийн хүрэлцээ үзүүлэлт

Санал болгож буй ногдол ашгийг тарааснаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтэд 0.40 нэгж хувийн нөлөө үзүүлэх ч ХасБанкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт байвал зохих хэмжээ болох 12.5%-иас өндөр хэвээр хадгалагдана.

2026 оны 1-р хагас	
Татварын дараах цэвэр ашиг (Тэрбум төгрөгөөр)	88.2
Санал болгож буй нийт ногдол ашиг (Тэрбум төгрөгөөр)	18.9
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (санал болгож буй ногдол ашиг тараахаас өмнөх байдлаар)	18.4%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (санал болгож буй ногдол ашиг тараасны дараах байдлаар)	18.0%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 26 оны 08. сарын 20. өдөр

№ R-2026-37

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6 (ii) дахь заалтыг тус тус үндэслэн, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 08 дугаар сарын 19-20-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банк нь 2026 оны эхний хагас жилийн байдлаар 88.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 18.4%-д хүргэж ажилласан болохыг;
2. Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
3. Банкны гүйцэтгэх удирдлага нь Банкны 2026 оны эхний хагас жилийн ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг ТУЗ-д санал болгосныг; мөн
4. ТУЗ нь Банкны Дүрмийн 8.6 (ii) дахь заалтын дагуу дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилах шийдвэр гаргуулахаар хувьцаа эзэмшигчдэд санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн баталсан тохиолдолд, Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.0 (арван найм) төгрөг зарлан хуваарилахыг дэмжсүгэй.
2. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг тухайн хурал зохион байгуулагдах хэлбэрээс үл хамааран Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Монголбанкнаас зөвшөөрч, хувьцаа эзэмшигчид баталсан тохиолдолд, Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Хагас жилийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 дугаар "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь бичгээр

урьдчилан хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]

2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг зарлан хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК (**“Банк”**)-ийн Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтаар Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (**“ТУЗ”**) Банкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах (**“Хагас жилийн ногдол ашиг”**)-ыг 2026 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн R-2026-37 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18.0 (арван найм) төгрөг зарлан хуваарилсугай.
2. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү тогтоол батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Хагас жилийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” 28 дугаар тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА



**Тооллогын комиссын
бүрэлдэхүүн**



ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны
08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-88 дугаар тогтоолын Хавсралт 3

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: Б.Ананд, Гүйцэтгэх захирал, Нөхөрлөлийн гишүүн, Кэй И
Партнерс ХХН

Комиссын гишүүд: М.Лхамсүрэн, Нөхөрлөлийн гишүүн, Кэй И Партнерс ХХН
Ү.Ананд, Хуульч, Өмгөөлөгч, Кэй И Партнерс ХХН



Саналын хуудасны загвар

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР



ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны
08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-38 дугаар тогтоолын Хавсралт 4

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар саналаа өгнө.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах	☐	☐	☐

Тайлбар/Санамж:

- Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) гэж тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
- Та эчнээ саналаа заасан хугацаанд зөвхөн ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгөх боломжтой.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд санал хүчинтэйд тооцогдоно.
- Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол санал хүчингүйд тооцогдоно.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудасны хүчин төгөлдөр байдал: Хүчинтэй / Хүчингүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл, хэрэв бий бол: _____

